

## 2014 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНУУДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

#### **НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР БА ХУДАЛДААНЫ ТАТВАР, ТЭДГЭЭРИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/203
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын даргын зөвлөх З.Нарантуяа
<i>Огноо:</i>	2014.02.28
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаагаар шууд бус татварын нийтлэг хувилбар болох Нэмэгдсэн өртгийн албан татвар болон Худалдааны татварын хувь хэмжээ, эрх зүйн зохицуулалт, эдгээр татваруудын хоорондын ялгаа, давуу болон сул тал зэргийг онолын ойлголт, зарим орны туршлага, олон улсын чиг хандлагад тулгуурлан харьцуулан судалсан болно. Үүнд: <ol style="list-style-type: none"><li>1. НӨАТ-ын системтэй орнууд: Индонез, Казахстан, Канад, Нидерланд, ОХУ, БНХАУ,</li><li>2. НӨАТ: Бараа ажил үйлчилгээний татвартай орнууд: Австрали, Чили,</li><li>3. Худалдааны татвартай орнууд: АНУ, Энэтхэг зэрэг орнуудыг сонгон авч татварын эрх зүйн зохицуулалтыг судалсан болно.</li></ol>

#### **ЭДИЙН ЗАСГИЙН ӨРГӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ЗАМААР ДАЛД ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ БИЗНЕСИЙГ ИЛ БОЛГОХ ТАЛААРХ ГАДААДЫН ОРНЫ ТУРШЛАГА**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/205
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог, Б.Байгалмаа, Ч.Онончимэг
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Д.Зоригт
<i>Огноо:</i>	2014.03.14
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд эдийн засгийн болон татварын өршөөл үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн ОХУ, Ирланд, Энэтхэг, Австрали, Аргентин, Колумб, Франц, Итали, Бельги зэрэг улсуудын туршлага, эерэг болон сөрөг үр дүнгийн талаар харьцуулсан судалсан.

#### **НЭМЭГДСЭН ӨРГИЙН АЛБАН ТАТВАРЫН “ХУУРАМЧ ПАДААН”-НЫ ОЙЛГОЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/208
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Билгээ, Д.Живгаагүнсэл, Ч.Онончимэг, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч С.Баярцогт
<i>Огноо:</i>	2014.06.02
<i>Сэдвийн агуулга:</i>	Энэхүү судалгаанд Нэмэгдсэн өртгийн албан татварын падааны арга, түүний давуу болон сул тал, “хуурамч” падааны талаарх ойлголт, үр дагавар, түүнээс сэргийлэх арга зам болон гадаадын зарим орны НӨАТ-ын падаан ашиглан хий бичилт хийж, татвараас зайлсхийх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг судлахыг зорилоо.

## **БАНКНААС ОЛГОХ ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ АКТИВ ХӨРӨНГӨ, БАТАЛГАА, БАТЛАН ДААЛТЫН ДЭЭД ХЭМЖЭЭ: БУСАД ОРНУУДЫН ЖИШИГ**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/218
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат
<i>Огноо:</i>	2014.10.06
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд дараах асуудлуудыг хамруулан авч үзлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- Банкнаас холбогдох этгээдэд олгох зээлийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалт, банкны үр дүнтэй хяналт шалгалтын олон улсын Базелийн зарчим болон Монгол Улсын эрх зүйн зохицуулалт;</li><li>- ОХУ болон Ирланд улсуудын Төрбанкны хуулийн зохицуулалт, хувь хэмжээний өөрчлөлтийг дэлгэрэнгүй байдлаар;</li><li>- Дэлхийн 124 орны холбогдох этгээдийг тодорхойлсон байдал, холбогдох этгээдэд олгох зээлд тавих хязгаарлалтын хэмжээ;</li><li>- Олон улсын байгууллагууд, гадаадын судалгааны байгууллагуудын холбогдох этгээдэд олгох зээлийн хэмжээтэй холбоотой гаргасан судалгаа, зөвлөмжийн тойм;</li><li>- Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтэрч болохгүй гэсэн зохицуулалтыг өөрийн хөрөнгийн 10 хувь болгон өөрчлөхөд нийгэм, эдийн засагт гарах эерэг сөрөг нөлөө, үр дагаврын талаарх мэргэжлийн байгууллага (Монгол банк)-ын дүгнэлт зэрэг болно.</li></ul>

## **ХУВЬЦАА БАРЬЦААЛАН ЗЭЭЛ АВАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/403
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Б.Байгалмаа, Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Ж.Батзандан
<i>Огноо:</i>	2014.02.18
<i>Сэдвийн агуулга:</i>	Тус судалгааны ажил нь хувьцааг барьцаалан зээл авах боломжийг гадаадын зарим орнуудад хэрхэн зохицуулдаг талаар судлахдаа БНЭУ, БНКУ, БНСУ, БНХАУ-ыг хамруулсан болно.

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд хувьцааг барьцаалж зээл авч болохыг Иргэний хууль, Гэрээний хууль, Компанийн хуулиар тус тус зөвшөөрч, хувьцааг барьцаалах процессын талаар БНЭУ нь Хадгаламжийн байгууллагын хуулиндаа, БНХАУ нь Үнэт цаасны хуулинд дэлгэрэнгүй заасан байна.

Хувьцаагаа барьцаалж зээл авах нь зөвхөн хувь хүн, хуулийн этгээдийн хувьд санхүүгийн эх үүсвэрээ шийдвэрлэх арга зам болох төдийгүй улс орны хувьд хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгсэл болгон ашиглаж байгаа талаар Энэтхэг улсын жишээн дээр харж болох юм.

Түүнчлэн, хувьцааг барьцаалан зээл олгогч тал буюу банк санхүүгийн байгууллагуудад тавигдах шаардлагыг хэрхэн зохицуулсан талаарх мэдээллүүд багтсан болно.

## **ДЭЛХИЙН ЭХНИЙ 30 ТОМ ЭДИЙН ЗАСАГ БҮХИЙ ОРНЫ ДНБ БА ТӨСВИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН ХАРЬЦАА**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/408
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.03.14  
*Сэдвийн агуулга:* Лавлагаа мэдээлэлд дэлхийн эхний 30 том эдийн засагтай орнууд болон Монгол Улсын 1) ДНБ-ний хэмжээ, 2) 1 хүнд ногдох ДНБ, 3) ДНБ-нд эзлэх улсын төсвийн зардал, 4) ДНБ-д эзлэх улсын гадаад өр, 5) ДНБ-д эзлэх татварын орлого, 6) ДНБ-д эзлэх улсын зээл зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулан гаргалаа.

### **ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-14/410  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Алтан-Оч  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.03.14  
*Сэдвийн агуулга:* Уг лавлагаа мэдээллийн судалгааны бичвэрт санхүүгийн зах зээлд гадаадын банк, санхүүгийн байгууллагын оролцоо, түүний нийтлэг нөлөө, Монголын санхүүгийн зах зээлд үзүүлэх эерэг, сөрөг нөлөө, банкны салбарт иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах арга хэрэгслүүдийн талаар тоймлон тусгасан болно.  
*Хайлтын түлхүүр үг:* санхүүгийн зах зээл, гадаадын банк, санхүүгийн байгууллагын оролцоо, банкны салбар, иргэд аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах

### **АНУ-ЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ХУУЛЬ, ҮНИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-14/421  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Алтан-Оч  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.08.07  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд АНУ-ын Монополийн эсрэг Шерманы хууль батлагдах болсон товч түүх, тус хуулийн зохицуулж буй харилцааны талаар мэдээлэл бэлтгэв. Түүнчлэн ОХУ, БНХАУ, Канад, ИБУИНВУ улсуудын өрсөлдөөний эрх зүйн ерөнхий зохицуулалт, үнийн ялгаварлан гадуурхалт болон үнийг хэлцэн тогтоохтой холбоотой зүйл заалтын талаарх мэдээллийг хамруулав.

### **ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН СОНИРХОЖ БУЙ ШИНЭ ЗАХ ЗЭЭЛ, ТЭДГЭЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АЛХАМУУД**

*Судалгааны код:* СТ-14/422  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Г.Билгээ, Д.Халиун  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар  
*Огноо:* 2014.08.20  
*Сэдвийн агуулга:* “Global finance” сэтгүүлийн 2014 оны 5 дугаар сарын дугаарт нийтлэгдсэн шинээр үүсэн хөгжиж буй шинэ зах зээлийн талаарх нийтлэлийг орчуулан тавилаа. Нийтлэлийг Уг нийтлэлд (1) Хөрөнгө оруулагчид тогтворгүй байдлыг үл харгалзан шинэ зах зээлүүдийг сонирхсон хэвээр байгаа талаар, (2) Шинэ зах зээлүүдийн өсөлтийг хэрхэн дэмжиж, амжилтад хүрэх алхмууд болон зарим үзүүлэлтүүдийг оруулсан байна.

## **КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ**

**Судалгааны код:** СТ-14/430  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Б.Ариунжаргал, А.Пагма  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Г.Батхүү  
**Огноо:** 2014.10.06  
**Сэдвийн агуулга:** Компанийн сайн засаглалын хүний нөөцийн бодлогыг хэрхэн тодорхойлдог талаар болон компанийн сайн засаглалын шинж чанар, зарчмуудыг тодорхойлж, хүний нөөцийн бодлогыг зорилго, үе шат, төрөл, хүний нөөцийн менежментийн стратегийн загваруудын талаар мэдээлэл, лавлагаа бэлтгэсэн.

## **МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАНГИЛАА АСУУДЛУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-14/431  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Р.Амаржаргал  
**Огноо:** 2014.10.06  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд макро эдийн засгийн бодлогын түвшинд төрөөс зайлшгүй хяналт тавьж зохицуулж байх шаардлагатай зангилаа асуудлууд болох ДНБ, инфляци, ажилгүйдэл, төсвийн алдагдал, гадаад худалдааны тэнцэл зэрэг асуудлуудын Монгол Улсын өнөөгийн төлөв байдлыг 2014 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, эдгээр асуудлын хүрээнд тулгамдаж буй асуудлууд, эрх зүйн орчны хүрээнд авсан арга хэмжээ, шинээр болон шинэчлэгдэн батлан гаргасан хууль, тогтоомжуудын талаар мэдээлэл лавлагааг бэлтгэлээ. Мөн Монгол Улсын эдийн засгийн салбарын үйл ажиллагааг зохицуулж буй хууль эрх зүйн орчны талаарх лавлагаа мэдээлэл бэлтгэн хавсаргасан болно.

## **ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ**

**Судалгааны код:** СТ-14/502  
**Судалгааны төрөл:** Дүн шинжилгээ  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог (Ph.D), Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Н.Номтойбаяр  
**Огноо:** 2014.05.28  
**Сэдвийн агуулга:** Энэхүү судалгаанд хөдөлмөрийн бүтээмжийн талаарх эдийн засгийн онолын ойлголт, төрөл хэлбэр, бүтээмжийг тооцох арга зүй болон эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (ДНБ, салбарын үйлдвэрлэл, ажиллах хүч, цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, инфляци) нь хөдөлмөрийн бүтээмжид хэрхэн нөлөөлдөг, тэдгээрийн хоорондын хамаарлын өнөөгийн байдлыг статистикийн шинжилгээний аргаар тооцсон болно.

## 2. НИЙГМИЙН БОДЛОГО

### СОЁЛЫН ӨВИЙН ХАМГААЛЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

*Судалгааны код:* СТ-14/207  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Д.Халиун  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батцэрэг  
*Огноо:* 2014.04.28  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд Австрали, Швейцар, Япон, Литв зэрэг орнуудын соёлын өвийн хамгааллын харилцаа, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэв. Судалгааны сэдвийн хүрээнд соёлын өвийн үнэлгээний асуудлуудыг зохицуулсан заалт буй эсэхийг судалж үзэхэд уг харилцааг шууд зохицуулсан заалт Литв улсад, Австрали, Япон, Швейцар орнуудад хуулиар зохицуулаагүй боловч холбогдох эрх зүйн актууд болон олон улсын хөрөнгийн үнэлгээний аргачлалыг ашиглаж тодорхойлдог байна.

### ГАНЦ БИЕ ЭЦЭГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХАНДЛАГА

*Судалгааны код:* СТ-14/219  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А. Пагма, Д.Живгаагүнсэл, Р.Нургүл, Б.Ариунжаргал  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батцогт  
*Огноо:* 2014.10.31  
*Сэдвийн агуулга:* Монгол болон гадаадын зарим оронд хүүхдээ өөрөө өсгөн хүмүүжүүлж буй ганц бие эцэгт үзүүлэх нийгмийн халамж, хөнгөлөлт, тэдгээрийн хууль эрх зүйн зохицуулалт, ганц бие эцэгт хандах нийгмийн хандлагын талаар судалсан болно.

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЗАРИМ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ, ХӨНГӨЛӨЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

*Судалгааны код:* СТ-14/220  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А. Пагма, Д.Живгаагүнсэл, Р.Нургүл  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ӨБХ-ны дарга Р.Бурмаа  
*Огноо:* 2014.12.01  
*Сэдвийн агуулга:* ОХУ, БНХАУ, БНСУ, ХБНГУ, Австрали улсуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, өндөр насны тэтгэвэр тогтоолгоход төрөөс үзүүлдэг дэмжлэг, хөнгөлөлтийн эрх зүйн зохицуулалтын талаар судалсан болно.

### ГАДААДЫН ЗАРИМ ОРОНД ГЭРЭЭСЭЭ СУРГУУЛЬД ЯВАХ БОЛОМЖГҮЙ БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН СУРАЛЦАХ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭДЭГ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА

*Судалгааны код:* СТ-14/401  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг

**Захиалагч:** УИХ-ын гишүүн, НББСШУБХ-ны дарга Д.Батцогт  
**Огноо:** 2014.01.17  
**Сэдвийн агуулга:** Захиалгын дагуу гэрээсээ сургуульд явах боломжгүй бага насны хүүхдийн суралцах асуудлыг ОХУ, Финлянд, АНУ хэрхэн шийдвэрлэдэг талаар мэдээлэл бэлтгэв.

### **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БА БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИНД ГАДААД ХЭЛ ЗААЖ ЭХЛЭХ НАСЫГ ХУУЛЬЧЛАН ТОГТООХ БОЛОМЖ, ЖИШИГ**

**Судалгааны код:** СТ-14/402  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Чулуун, Д.Живгаагүнсэл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Г.Уянга  
**Огноо:** 2014.01.27  
**Сэдвийн агуулга:** Мэдээлэлд хүүхдийг багаас нь үндэсний үзэл бахархлаар хүмүүжүүлэх зорилгоор гадаадын улс оронд тодорхой насанд хүртэл хүүхдэд гадаад хэл заалгүй зөвхөн үндэсний хэл заадаг, эсхүл, үүнтэй төстэй эрхзүйн арга механизм хэрэглэдэг арга тогтолцоо байдаг эсэх”, “хүүхдийн үндэсний хэл сэтгэхүйн дархлаа тогтдог насыг тодорхойлсон шинжлэх ухааны үндэслэл байдаг эсэх”-ийг судлан оруулсан болно.

### **ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ БОЛОН ТЭДЭНД БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-14/406  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Оюун  
**Огноо:** 2014.02.24  
**Сэдвийн агуулга:** Судалгааны захиалгын дагуу Унгар улсын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх кондактив үйлчилгээний тухай, Швед улсад хүүхдийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт (0-3 нас) илрүүлэх тогтолцоо, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, АНУ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын тухай хуулийн С хэсгийн зохицуулалтын талаар мэдээлэл бэлтгэв.

### **УНАДАГ ДУГУЙГААР ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ, ГАДААДЫН ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-14/413  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Чулуун, Ө.Мөнхтунгалаг  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Ж.Батзандан  
**Огноо:** 2014.04.07  
**Сэдвийн агуулга:** Нийгэм эдийн засгийн байдлаараа Монгол Улстай төстэй болон дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад,  
а) унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд оролцох эрх зүйн зохицуулалт;  
б) авто зам, явган замын байгууламжийн дэргэдэх дугуйн зам; ямар байдаг, тухайн асуудлуудыг шийдэж ирсэн арга-туршлага, онцлогийн талаар гаргасан [манай] лавлагаа “Дугуйтай зорчигчийн орчин нөхцлийг эрх зүйн болон зам байгууламжийн норм норматив талаас нь ханган бүрдүүлэх зарим асуудал” (А), “Унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд

оролцохыг дэмжих бодлого, гадаадын туршлага (В) гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Мэдээллийн а) хэсгийг Тамгын газрын судалгааны албаны ажилтан Г.Чулуун, б) хэсгийг судлаач, референт Ө.Мөнхтунгалаг боловсруулж, Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга д-р. Ц.Норовдондог хянажээ.

## **ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН НИЙГМИЙН ДААТГАЛ БОЛОН ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН ТОГТОЛЦОО, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВТ ЭЗЛЭХ ХУВЬ ХЭМЖЭЭ**

**Судалгааны код:** СТ-14/415  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ  
**Огноо:** 2014.05.13  
**Сэдвийн агуулга:** Энэхүү судалгаагаар дэлхийн улс орнуудын нийгмийн хамгаалал, тэтгэврийн хуримтлалын тогтолцоог харьцуулан судлах, дэлхийн улс орнууд болон Монгол Улсын нийгмийн халамжийн зардлын төсөвт эзлэх хувь хэмжээг гаргахыг зорьсон бөгөөд судалгаанд дэлхийн 193 орны холбогдох статистик мэдээллийг харьцуулсан болно.

## **АХМАД УУРХАЙЧДЫН ТЭТГЭВЭР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АСУУДЛЫГ ЭРХ ЗҮЙН ТАЛААС НЬ ЗОХИЦУУЛСАН ГАДААДЫН УЛС ОРНЫ ЗАРИМ ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-14/417  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Чулуун (Судалгааны албаны ажилтан, референт)  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Р.Бурмаа  
**Огноо:** 2014.06.09  
**Сэдвийн агуулга:** Лавлагаанд, газрын гүнд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад уурхайчдын нийгмийн хамгааллын зарим асуудлыг гадаадын улс орнуудад хэрхэн анхаарч, эрх зүйн талаас нь яаж зохицуулж байгааг ОХУ, ХБНГУ, Казахстан Улс, Украин Улсын жишээ туршлагаар өгүүлэв.

ОХУ -ын тэтгэврийн сангийн тусгай данс, ахмад уурхайчдын тэтгэврийн нэмэлт, Казахстан Улсын №414-I дугаарт хууль (1999) –ийн дагуу, Казахстанд, уул уурхайн онцгой хүнд хортой нөхцөлд ажиллаж байсан, хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэрт гарсан (1998.01.01 өмнө хуульд заасан болзол нөхцөлийг хангасан) хүмүүст олгодог “улсын тусгай тэтгэмж” –ийн талаар, мөн Украин Улсын уурхайчны хөдөлмөрийн үнэ цэнийг өргөх арга хэмжээний тухай хуулийн агуулгын онцлогийг дурджээ.

## **ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН АСУУДЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

**Судалгааны код:** СТ-14/423  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт  
**Огноо:** 2014.09.05  
**Сэдвийн агуулга:** Мэдээлэл лавлагаанд Монгол Улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал болон бусад статистик мэдээллүүдийг хавсаргав. Үүнд:  
1. Даатгуулсан иргэдийн тоог аймаг, дүүрэг тус бүрээр хүйс, насны

- ангиллаар,
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчийн тусламж үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө сүүлийн 10 жилийн,
  3. Эрүүл мэндийн үйлчилгээнд төлбөр тусламж авсан хүний тоо сүүлийн 10 жилээр,
  4. Төрөөс шимтгэлийг дааж буй иргэдийн тоо сүүлийн 10 жилээр.

### **МАЛЧИН ИРГЭДИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-14/424  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт  
*Огноо:* 2014.09.05  
*Сэдвийн агуулга:*

Судалгаанд ҮСХ-ноос ирүүлсэн аймаг, сумдын малчин иргэдийн тооноос харахад манай улсын малчин иргэдийн тоо жил тутам 2000 орчим иргэдээр буурах хандлагатай байгаа бөгөөд харин малчин иргэдийн шилжилт хөдөлгөөн төв суурин газар, аймгийн төвийн бүсүүдэд нэмэгдэж байна.

Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдлыг үзэхэд 2009 онд нийт 88353 малчид даатгуулж байсан бол 2013 онд 118601 болж, эрүүл мэндийн даатгалд даатгуулагч малчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна.

60-аас дээш насны малчин иргэдийн тоо 2009 онд 48172 байсан бол 2013 онд 27744 болж буурсан байна.

### **АХМАД НАСТНЫ АСРАМЖ, ХАЛАМЖИЙН АСУУДЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-14/425  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт  
*Огноо:* 2014.09.05  
*Сэдвийн агуулга:*

Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрууд дэлхийн олон оронд түгээмэл байгаа бөгөөд эдгээр асрамжийн газрууд нь асрамж шаардлагатай өндөр настнуудыг нийгмийн харилцаанд байлгах, бусад ахмад настнууд болон хамт олон дунд байх хэрэгцээг хангах, ая тухтай амьдрах орчныг бий болгох, шаардлагатай асрамж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр төрөлжсөн асрамжийн газрууд нь цогцолбор хэлбэртэй, өмчлөлийн хувьд улсын, улс-хувийн хэвшлийн хамтарсан, хувийн зэрэг янз бүрийн харьяалал, санхүүгийн эх үүсвэртэй байна. Судалгаанд эдгээрээс сүүлийн үед түгээмэл бий болж байгаа асрамжийн газрын хэлбэрүүд болон ахмад настны халамж, асрамжийн талаарх Монгол Улсын статистик мэдээлэл зэргийг хамруулсан болно.

### **ХҮҮХЭД, ЗАЛУУС, ГЭР БҮЛИЙН АСУУДЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-14/426  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт  
*Огноо:* 2014.09.05

*Сэдвийн агуулга:* Гэр бүлийн байдал нь хүн ам зүйн нэг гол үзүүлэлт төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад ач холбогдолтой юм. Судалгаанд Үндэсний статистикийн хорооноос 10 жилд нэг удаа зохион байгуулдаг “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүнг суурь мэдээлэл болгосон бөгөөд энэхүү тооллогын хүрээнд гарсан сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн мэдээллийг ашигласан болно.

### **МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-14/428  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт  
*Огноо:* 2014.09.05  
*Сэдвийн агуулга:* Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2009 оноос хойших хугацааны дараах тоон мэдээллүүдийг гаргаж, холбогдох дүгнэлтийг гаргасан. Үүнд:

1. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаар суралцаж төгсөгчдийн ерөнхий төлөв байдал, төгсөгчдийн тоо;
2. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал;
3. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив (аймаг нийслэлээр);
4. Мэргэжлийн сургалтанд хамрагдагсдын тоо, зарцуулсан хөрөнгө;
5. Ажиллах хүчний эрэлт нийлүүлэлт ба зах зээлийн эрэлтийн судалгаа, Хөдөлмөрийн зах зээлийн Барометрийн судалгаанаас хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн сүүлийн 4 жилийн байдлаар дэлгэрэнгүй оруулсан.

### **ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙГ “ГАЛЫН ОСЛЫН ЗААВАЛ ДААТГАЛ”-Д ХАМРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ ЖИШИГ, ГАДААДЫН ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-14/432  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г. Алтан-оч, Г.Чулуун, Ө.Мөнхтунгалаг, И.Жаргалзаяабямба  
*Захиалагч:* УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Д. Ганбат  
*Огноо:* 2014.11.17  
*Сэдвийн агуулга:* Үл хөдлөх хөрөнгийг галын албан журмын даатгалд хамруулах арга боломжийн талаар гадаад орнуудын хууль тогтоомжид судалгаа хийж, тухайн орны онцлог шинж чанаруудыг бусад орны бие даасан хууль, журмуудтай харьцуулан судалсан болно.

### 3. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ГАДААД БОДЛОГО

#### ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙГ СОНГОГЧДЫН САНАЛААР ЭГҮҮЛЭН ТАТАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

*Судалгааны код:* СТ-14/202  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч, Б.Байгалмаа, Г.Билгээ, Ц.Болормаа, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Ч.Онончимэг, А.Пагма, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа  
*Огноо:* 2014.01.21  
*Сэдвийн агуулга:* Иргэдийн нийтлэг эрх ашгийг төлөөлж сонгогдсон этгээдийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас нь өмнө сонгогчдын саналаар эгүүлэн татахтай холбоотой бусад орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлав.

#### ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИН, ХӨЛС, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА

*Судалгааны код:* СТ-14/204  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма, Ц.Болормаа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан  
*Огноо:* 2014.02.18  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд Герман, Молдов, Америк зэрэг улсын төрийн албан хаагчийн цалин хөлсний системийн талаарх харьцуулсан судалгааг гүйцэтгэв. Олон улсын практикт төрийн албан хаагчдын хөдөлмөрийн хөлсний систем нь Төрийн албаны ямар загвар сонгон авснаас шалтгаалан ялгаатай байдаг. Төрийн албаны карьерийн болон албан тушаалын (position) буюу позицгийн гэсэн хоёр загвар байдаг. Карьерийн загвартай оронд бол цалин нь мөнгөн дүнгээр бага боловч төрийн албан хаагчийн нийгмийн хамгааллын асуудлыг нь илүү сайн анхаардаг, позицгийн загвартай оронд бол цалин нь хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхүйц өндөр боловч нийгмийн хамгааллын асуудалд нь бага анхаардаг.

#### ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН СУДАЛГААНЫ АЛБАДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Судалгааны код:* СТ-14/210  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма, Ц.Болормаа, Ө.Мөнхтунгалаг, Д.Халиун  
*Захиалагч:* Судалгаа, шинжилгээний хэлтэс  
*Огноо:* 2014.06.10  
*Сэдвийн агуулга:* Улс орнуудын парламентын дэргэдэх ажлын албаны бүтэц, зохион байгуулалтаас үзэхэд судалгааны нэгж нь парламентын ажлын албаны үндсэн бүтэцэд, эсхүл парламентынхаа харьяанд харьцангуй бие даасан (ажлын албатайгаа ижил статустай) хэлбэрээр ажилладаг байна. Тус судалгаанд парламентын судалгааны нэгж нь парламентын ажлын албатай ижил статустай ба бие даасан эрх зүйн актаар үйл ажиллагаа нь зохицуулагддаг АНУ-ын Конгрессийн Судалгааны алба /КСА/, Австралийн Парламентын номын сан, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Хурлын Судалгааны алба, Японы Парламентын номын сангийн эрх зүйн зохицуулалтыг дэлгэрэнгүй авч үзэв.

## **ТӨРИЙН УДИРДЛАГЫН ШИНЭЧЛЭЛ: ОНОЛЫН ХӨГЖИЛ, ЗАРЧИМ, ДЭЛХИЙ НИЙТИЙН ХАНДЛАГА**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/211
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Хатанбаатар, Г.Чулуун, А.Пагма, Ц.Болормаа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Б.Бакей
<i>Огноо:</i>	2014.06.25
<i>Сэдвийн агуулга:</i>	Төрийн удирдлагын тухай онолын хөгжил, чиг хандлагын тойм, ХХ дугаар зууны сүүлч, XXI дүгээр зууны эхэнд дэлхийн зарим улс орнуудад хийгдсэн төрийн удирдлагын шинэчлэлийн туршлага, сургамж, сайн засаглалын зарчим, Японы туршлага, цахим засаг, дэлхий нийтийн хандлага, ухаалаг төрийн зарчим, ХБНГУ, АНУ-ын туршлага зэрэг асуудлыг уг судалгааны хүрээнд дэлгэрэнгүй авч үзсэн.

## **ИРГЭДЭЭС ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ НЭГДСЭН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/213
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Чулуун, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Р.Бурмаа
<i>Огноо:</i>	2014.07.09
<i>Сэдвийн агуулга:</i>	Захиалгын дагуу Энэтхэг, Украин, Австрали, Канад, Казахстаны иргэдээс өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх, бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох улсын хэмжээний нэгдсэн тогтолцоотой эсэх, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах асуудлыг хэрхэн уялдуулан шийдвэрлэж байгаа туршлагыг харьцуулан судалсан.

## **ЗАРИМ ОРНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/214
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Хатанбаатар, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг, Д.Халиун
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Б.Болор
<i>Огноо:</i>	2014.07.04
<i>Сэдвийн агуулга:</i>	Манай улстай адил Үндсэн хуулийн хяналтын эрх зүйн тогтолцоотой улсууд болох Австри, Словени, Латви зэрэг улсын Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын талаар харьцуулан авч үзлээ. Ингэхдээ эдгээр улсуудын Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтанд манай улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтаас ялгаатай онцлог асуудлыг анхааран тусгав.

## **ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ХУВИЙН ХЭВШЛЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АСУУДАЛ, МОНГОЛ УЛС БА БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ХАНДЛАГА**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/215
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог, А.Пагма, Б.Ариунжаргал, О.Нарантуяа, Т.Мягмаржав, Р.Нургүл
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл
<i>Огноо:</i>	2014.09.04

**Сэдвийн агуулга:** Энэхүү судалгаа нь төрийн байгууллагуудын гүйцэтгэж байгаа зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг төрийн бус байгууллагуудад шилжүүлэх болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэлбэрийг тодорхойлох, Австрали, Их Британи, Канад, АНУ, ОХУ зэрэг улсад энэ чиглэлээр төрийн салбарт шинэчлэл хийсэн туршлагыг харьцуулан судалж, дүгнэлт гаргахад чиглэгдсэн болно. Мөн Монгол Улсын төр-хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин ямар байгааг тодруулан захиалагчид мэдээлэл лавлагаа гаргаж өгөхөд чиглэгдэнэ.

## **НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН ТЭДГЭЭРИЙН БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДЛЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

**Судалгааны код:** СТ-14/216  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог, Г.Чулуун, Д.Халиун, Д.Живгаагүнсэл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл  
**Огноо:** 2014.09.04  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Монгол Улс, БНСУ болон Европын Холбооны орнуудын Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн өнөөгийн байдал болон тэдгээрийн бие даасан хараат бус байдлын талаарх мэдээллийг харьцуулсан болно.

## **ТӨРИЙН АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-14/217  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, Г.Билгээ, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Г.Батхүү  
**Огноо:** 2014.09.09  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Австрали, Азербайжан, Герман болон Франц зэрэг улсуудын төрийн албаны эрх зүйн дараах асуудлыг хамруулав. Үүнд:

- Төрийн албаны харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн орчин,
- Төрийн албаны төв байгууллага, түүний бүтэц, орон тоо, харьяалал,
- Төрийн албаны дарга, орон тооны гишүүдийг санал болгодог субъект,
- Төрийн албаны зэрэг дэв, сонгон шалгаруулалт,
- Төрийн албаны тангараг,
- Төрийн албан хаагчийг ажлаас халах үндэслэл,
- Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм.

## **ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛД ҮЙЛЧИЛЖ БУЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

**Судалгааны код:** СТ-14/405  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Чулуун  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан  
**Огноо:** 2014.02.18  
**Сэдвийн агуулга:** Төрийн албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшил, тэтгэвэрт гарахад нь болон амь насаа алдахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тусламж, нэмэгдэл амралт, ажилласан жил нэмэгдүүлэн тооцох, ажилласан жилийг нь харгалзан олгох нэг удаагийн мөнгөн тусламж .. зэргийг салбарын хуулиудад хэрхэн тусгагдсаныг

харьцуулах, [тэдгээрийн агуулгад зарим] давхцал зөрчил бий эсэхийг тодруулах чиглэлээр гаргасан энэ лавлагаа дотроо 9 дэд гарчигтай, дэлгэрэнгүй өгүүлэмжтэй.

#### **ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙГ [СОНГОГЧДЫН САНАЛААР] ЭГҮҮЛЭН ТАТАХ” АСУУДЛЫГ ҮНДСЭН ХУУЛИЙН АГУУЛЫН ХҮРЭЭНД [ХАМААТУУЛАН] АВЧ ҮЗЭХ БОЛОМЖ, ЖИШИГ, ХАНДЛАГА**

*Судалгааны код:* СТ-14/407  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Алтан-Оч, Г.Чулуун  
*Огноо:* 2014.01.21  
*Сэдвийн агуулга:* Парламентын гишүүнийг эгүүлэх татах .. явдлыг гадаадын улс орнуудад хэрхэн үздэг, яаж зохицуулдаг ерөнхий тойм гаргах үүднээс (зарим хууль санаачлагчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу) Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгаа шинжилгээний хэлтэс дэлхийн улс орнуудын конституцийн агуулгаас тухайн асуудалд холбогдох сэдэвчилсэн тойм мэдээлэл бэлтгэв. Тоймд, дэлхийн 149 орны конституцийн агуулгаас авсан түүвэр мэдээлэл (нийт 10 хүн бүхий судалгааны багийн ажлын тайлан) –ийг ахлах реф. Р. Хатанбаатар, реф. д-р. Г.Алтан-Оч, Г.Чулуун нар нэгтгэж, парламентын гишүүний мандатын хэв шинжийг тодруулсан ерөнхий “зураг” гаргажээ.

#### **ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД, БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ОЛГОЖ БУЙ ВИЗИЙН ГОРИМ, НӨХЦӨЛ, ТААТАЙ БОЛОМЖ, ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-14/411  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Живгаагүнсэл  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.04.01  
*Сэдвийн агуулга:* Уг судалгаанд манай улсаас гадаадын хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдэд олгож буй визийн горим, дэглэмийг дэлхийн зарим орны тухайлбал, АНУ, БНКаЗУ-ын сайн туршлагатай харьцуулан судалж, түүнийг илүү уян хатан, тааламжтай болгох боломжуудыг тодорхойлохыг зорив.

#### **МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАЖ БУЙ БАЙДАЛ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БА ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ТУХАЙ ОНОЛ, ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА**

*Судалгааны код:* СТ-14/416  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ө.Мөнхтунгалаг, Д.Живгаагүнсэл, Р.Нургүл  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Г.Уянга  
*Огноо:* 2014.06.03  
*Сэдвийн агуулга:* Захиалгын дагуу Монгол Улсын олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид тусгаж буй байдал, олон улсын гэрээ ба үндэсний хууль тогтоомжийн харилцан хамаарлын тухай онол арга зүй, олон улсын хандлагад тулгуурлан мэдээлэл лавлагаа бэлтгэв.

#### **МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД, ТЭДГЭЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН**

*Судалгааны код:* СТ-14/418  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог, Ц.Болормаа, Д.Халиун, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

**Захиалагч:** Судалгаа, шинжилгээний хэлтэс

**Огноо:** 2014.06.20

**Сэдвийн агуулга:** Лавлагаа мэдээлэлд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа судалгаа, шинжилгээний байгууллагууд, тэдгээрийн мэдээллийн санг УИХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах боломжийн талаарх санал, дүгнэлт оруулсан. Хавсралтаар дараах байгууллагуудын мэдээллийн санг хавсаргав. Үүнд:

- Шинжлэх ухаан технологийн сан, Шинжлэх ухааны академи, түүний харьяа хүрээлэнгүүд,
- Төрийн байгууллагуудын судалгааны нэгжүүд,
- Судалгаа, шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд,
- Их, дээд сургуулиудын судалгааны газрууд.

Мөн “Мэдээллийн нэгдсэн сан байгуулах тухай” Засгийн газрын 214 дүгээр тогтоол, “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Сайдын 187 дугаар тушаалыг хавсаргав.

#### **МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ**

**Судалгааны код:** СТ-14/419

**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа

**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар

**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Дэмбэрэл

**Огноо:** 2014.07.03

**Сэдвийн агуулга:** 2010 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2011 онд шинэчлэн батлагдсан Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн үнэлж, санал дүгнэлт гаргах зорилгоор Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгийн хэрэгцээнд зориулж ГХЯ-наас бэлтгэн ирүүлсэн “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтийн явц. (Гадаад бодлогод холбогдох хэсэг)” болон “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтийн явц (2011-2014 он)” зэрэг материалд дүн шинжилгээ хийв.

#### **ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХАНДЛАГА, 1992 ОНООС ХОЙШХИ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН ӨӨРЧЛӨЛТ**

**Судалгааны код:** СТ-14/420

**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа

**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Билгээ, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

**Захиалагч:** УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей

**Огноо:** 2014.07.04

**Сэдвийн агуулга:** Судалгааны ажлыг “Ухаалаг төр рүү шилжих” Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд УИХ-ын ТББХ-ноос 2014 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу ТББХ-ны даргын захиалгаар гүйцэтгэв. Судалгаанд Засгийн газрын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтын талаарх нийтлэг ойлголт, өөрчлөлтийн чиг хандлага болон Монгол Улсын Засгийн газрын 1992 оноос хойшхи бүтэц, чиг үүргийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг лавлагаа болгон орууллаа.

## **ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮН БУЮУ ЕРӨНХИЙ САЙДЫГ ТОМИЛДОГ ЕРӨНХИЙ ДЭГ**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/433
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Алтан-Оч, Б.Ариунжаргал, Г.Билгээ, Ч.Онончимэг, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей
<i>Огноо:</i>	2014.11.19
<i>Сэдвийн агуулга:</i>	<p>Энэхүү лавлагаа, мэдээллийн хүрээнд дэлхийн 169 орны гүйцэтгэх засаглалын тэргүүн, ерөнхий сайдыг хэрхэн томилдог талаар судалсан болно. Үүнээс үзэхэд дээрх орнуудад гүйцэтгэх засаглал, Ерөнхий сайдыг дараах байдлаар томилдог байна.</p> <ul style="list-style-type: none"><li>- Ерөнхийлөгчөөс шууд томилдог – 79 орон;</li><li>- Ерөнхийлөгч томилж, Парламент баталдаг – 21 орон;</li><li>- Ерөнхийлөгч нэр дэвшүүлж, Парламент баталдаг – 6 орон;</li><li>- Парламентаас шууд томилдог – 14 орон;</li><li>- Эзэн хаанаас гүйцэтгэх засаглалыг томилдог – 23 орон;</li><li>- Амбан захирагч томилдог – 11 орон;</li><li>- Сонгуулиар гүйцэтгэх засаглалыг томилдог – 6 орон;</li><li>- Бусад /шашин, цэргийн, ерөнхийлөгч Засгийн газрын тэргүүн байх гэх мэт/ - 3 орон тус тус байна.</li></ul>

## **ЗАСГИЙН ГАЗРЫГ БҮРДҮҮЛЭХ ТАЛААРХ ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

<i>Судалгааны код:</i>	СТ-14/434
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлагаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Алтан-Оч, Б.Ариунжаргал, Г.Билгээ, Ч.Онончимэг, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Д.Ганхуяг
<i>Огноо:</i>	2014.12.01
<i>Сэдвийн агуулга:</i>	<p>Украин, ХБНГУ, Нидерланд, БНСУ, Канад зэрэг орнуудын улс төрийн нам, эвслүүд олонхын суудал аваагүй тохиолдолд Засгийн газрын бүрдүүлэх журам, парламентад бүлэгтэй нам, эвслүүдийн оролцоог хангах замаар Засгийн газрыг бүрдүүлдэг эсэх асуудлаар эрх зүйн зохицуулалт, туршлагыг судалсан болно.</p>

#### 4. ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ САЛБАРЫН БОДЛОГО

##### **ОФФШОР БҮС, ОФФШОР БҮСЭД КОМПАНИ БАЙГУУЛАХ, ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХТЭЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦАА БОЛОН ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН ОФФШОР БҮСЭД ДАНС НЭЭХ, ХӨРӨНГӨ ЭЗЭМШИХ, АШИГЛАХЫГ ХЯЗГААРЛАХ АСУУДЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-14/201  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Б.Байгалмаа, Г.Билгээ, Ч.Онончимэг  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей,  
УИХ-ын гишүүн Ж.Батзандан  
*Огноо:* 2014.01.14  
*Сэдвийн агуулга:* Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дараах асуудлуудыг тодруулахыг зорьсон болно. Үүнд:

- Оффшор бүсийн тухай ойлголт, тодорхойлолт,
- Оффшор бүсэд компани байгуулах, банк, банк бус санхүүгийн байгуулагад данс нээх,
- Энэ талаарх гадаадын зарим орны төрийн бодлого, эрх зүйн зохицуулалт,
- Төрийн өндөр албан тушаалтан оффшор бүсэд данс нээхийг хориглох тухай бусад орнуудын эрх зүйн зохицуулалтыг судлах зэрэг болно.

Судалгаанд оффшор бүсийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн буюу оффшор бүсийг харьяалж байгаа орнуудын оффшор бүсэд компани байгуулахыг зөвшөөрсөн эрх зүйн зохицуулалтын жишээ болгон БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс болох Макаогийн холбогдох хуулийн зохицуулалтыг оруулсан бол харин оффшор бүсэд төрийн өндөр албан тушаалтан данс нээх, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хөрөнгө болон үнэт зүйлс хадгалахыг хориглосон эрх зүйн зохицуулалттай орны жишээ болгон ОХУ-ын туршлагыг судалж, Украин улс энэ чиглэлийн хязгаарлалт хийхийг зорьж байгаа Дээд Рада-д өргөн барьсан хуулийн төслийн талаарх мэдээллүүд багтсан болно.

##### **КАЗИНО, БООЦООТ ТОГЛООМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХИЙГ ЗӨВШӨӨРДӨГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-14/206  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Болормаа, Д.Халиун  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.04.01  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд АНУ, БНСУ, Макао, Сингапур улсуудын казиногийн орлого болон татварын харьцуулсан мэдээлэл, эрх зүйн ерөнхий зохицуулалт, түүнчлэн казиногийн эдийн засаг болон нийгмийн салбарт үзүүлэх эерэг, сөрөг үр нөлөө, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавраас хамгаалах механизм болон дотоодын иргэдэд нээлттэй эсэх талаарх мэдээллийг хамруулав.

##### **АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРИМ ЗААЛТТАЙ ХОЛБОГДОХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-14/209  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Болормаа, Г.Билгээ, Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, ЭЗБХ-ны дарга Б.Гарамгайбаатар

**Огноо:** 2014.06.03  
**Сэдвийн агуулга:** Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд заасан “Үндэсний геологийн алба”-ны эрх зүйн статус, үндсэн чиг үүргийг судлахдаа АНУ, Канад, Унгар, Узбекистаны холбогдох байгууллага, түүний эрх зүйн үндсийг тогтоосон хууль, хуульчилсан актын хүрээнд харьцуулан судалсан. Мөн хуулийн төсөлд заасан “мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч” гэх субъектийн олон улсын туршлагыг судлахдаа тухайлсан нэг орныг судлахаар зориогүй бөгөөд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр үйлчилж буй стандартыг гол судлагдахуун болгосон бөгөөд тус стандартыг хэчнээн улс, хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх туршлагыг судалсан болно.

### **КАЗИНО БАЙГУУЛАХ, АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БОЛОН КАЗИНО, БООЦООТ ТОГЛООМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХИЙГ ЗӨВШӨӨРДӨГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-14/212  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Болормаа, Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Ганбат  
**Огноо:** 2014.06.20  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд АНУ, БНСУ, Макао, Сингапур улсуудын казиногийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн ерөнхий зохицуулалт, түүнчлэн казиногийн эдийн засаг болон нийгмийн салбарт үзүүлэх эерэг, сөрөг үр нөлөө, нийгэмд үзүүлэх сөрөг үр дагавраас хамгаалах механизм зэрэг мэдээллийг хамруулав. Түүнчлэн АНУ, БНСУ, МАКАО, Сингапур улсуудын казино, бооцоот тоглоомын орлогын хэмжээг жилээр харьцуулан гаргаснаас гадна бооцоот тоглоомын орлогод ногдуулдаг татварын төрөл, хувь хэмжээ, мөн энэ төрлийн татварын орлогын хуваарилалтын талаар АНУ-ын 22 мужийн туршлагыг харьцуулан судаллаа.

Монгол Улсын хувьд казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг 1999.01.22-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хуулийн үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалтын талаар товч авч үзсэн болно.

### **МОНГОЛ УЛСЫН БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОЖ ИРСЭН БАЙДАЛ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ БҮСИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОДОГ ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-14/404  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Д.Живгаагүнсэл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Оюун  
**Огноо:** 2014.01.18  
**Сэдвийн агуулга:** Судалгааны сэдвийн хүрээнд бүсийн нэмэгдэл олгох шаардлагатай бүс нутгийг тогтоох онолын үндэслэл, шалгуур үзүүлэлт, Монгол Улсад бүсийн нэмэгдэл олгож байсан туршлага, холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудын талаарх мэдээлэл, гадаадын зарим оронд бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд бүсийн нэмэгдэл олгодог туршлага зэрэг асуудлуудыг тусгасан болно.

### **ТӨМӨР ЗАМЫН ЯЛГААТАЙ ЦАРИГИЙН ҮЕД АШИГТ МАЛТМАЛЫН ЭКСПОРТЫН ЗАРИМ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХИЛИЙН БООМТУУД ДЭЭР ШИЛЖҮҮЛЭН АЧИХАД ГАРАХ ЗАРДЛЫН ТОЙМ ТООЦОО**

**Судалгааны код:** СТ-14/409

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Чулуун  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.03.14  
*Сэдвийн агуулга:* БНХАУ –тай Монголын талаас өргөн царигийн төмөр замаар холбогдож байгаа нөхцөлд, манай улсын экспортын гол нэрийн зарим бүтээгдэхүүн (нурмаг ачаа) -ийг хилийн боомт дээр шилжүүлэн хэд гарах зардлын тооцоог захиалагчийн өгөгдөлд тулгуурлан Зам тээврийн яам гаргасан. Товч лавлагаанд, салбарын яамны тооцооны аргачлалын онцлог, Монголын ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортын гол нэрийн ачаа барааг зөөх тусгай зориулалтын төмөр замыг барихдаа шилжүүлэн ачилт, тээх нэвтрүүлэхийн аливаа хүндрүүлсэн нөхцөлөөс ангид байлгахын чухлыг тодотгосон холбогдох мэдээллийг нэгтгэн тоймложээ.

### **МОНГОЛ УЛС БОЛОН БНХАУ-ЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ 2015-2025 ОНЫ ХУВААРЬТАЙ ТӨСӨӨЛӨЛ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ИТПОРТЫН ТООЦОО, МОНГОЛ УЛСЫН СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ НӨӨЦ**

*Судалгааны код:* СТ-14/412  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.04.01  
*Сэдвийн агуулга:* Судалгаанд гурван асуудлын хүрээнд мэдээлэл лавлагааг бэлтгэсэн. Үүнд:  
- Монгол Улсын эрчим хүчний хэрэглээний 2015-2025 оны хуваарьтай таамаглалын хувьд мэргэжлийн нарийн тооцоолол шаардагдах учир эрчим хүчний хэрэгцээний өсөлтийн хувилбаруудын тооцоолол,  
- БНХАУ-ын эрчим хүчний салбарын өнөөгийн болон 2015-2030 оны эрчим хүчний хэрэглээний чиг хандлагын мэдээлэл,  
- Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөцийн хувь салхи, нар, усны боломжид тулгуурласан нөөцийн мэдээлэл зэргийг тусгасан болно.

### **ХЭЭЛТЭГЧ ЭХ МАЛЫН ТОО, ТЭДГЭЭРЭЭС АВАХ СҮҮ СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-14/414  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Зоригт  
*Огноо:* 2014.04.01  
*Сэдвийн агуулга:* Судалгаа, шинжилгээний хэлтсээс Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Хээлтэгч эх малын тоо, тэдгээрээс авах сүү сүүн бүтээгдэхүүнтэй холбоотой лавлагаа мэдээлэл” сэдэвт мэдээлэл лавлагааг бэлтгэв. Тус судалгааны мэдээлэлд Үндэсний статистикийн хороо, Үйлдвэр хөдөө аж ахуйн яам, Хүнсчдийн нэгдсэн холбоо, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн дараах мэдээллийг багтаав.  
Үүнд:  
1. Улсын хэмжээний үнээ, эм хонь, эм ямаа, гүү, ингэний тоог аймаг, сум бүрээр,  
2. Монгол үнээ, сүүний чиглэлийн үнээ, сарлаг, хайнаг, эм хонь, эм ямаанаас нэг өдөрт саах сүүний хэмжээ, саалийн хугацаа, сүүн дэх тослогийн хэмжээ,  
3. Цагаан идээний импортын хэмжээ, нэр төрлөөр, үнийн дүнгээр.  
4. Улсын хэмжээнд хэрэглэх цагаан идээний хэрэгцээ нэр төрлөөр.

### **ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА МЭДЭЭЛЭЛ**

**Судалгааны код:** СТ-14/427  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол Ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт  
**Огноо:** 2014.09.05  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд (1) ААН-ийн ажиллагсадын тоо болон тухайн жилийн борлуулалтын орлого нь харилцан адилгүй байх бөгөөд 2011-2013 оны байдлаар ААН-ийн ажиллагсдын тоо, борлуулалтын орлогыг он тус бүрээр гаргасан. Түүнчлэн (2) төрөөс ЖДҮ-г дэмжих зээл авсан, (3) гаалийн татвараас чөлөөлөгдсөн тоног төхөөрөмж авсан ААН, иргэдийн мэдээлэл, (4) жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татвар төлөлт, (5) татан буугдсан ННУ-ийн тоо, үйл ажиллагааны талаарх мэдээллийг багтаасан.

### **ХОТЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ КАЗАХСТАН УЛСЫН ЭРХЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА**

**Судалгааны код:** СТ-14/429  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Алтан-Оч, Р.Нургүл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн, ЭЗБХ-ны дарга Б.Гарамгайбаатар  
**Огноо:** 2014.09.12  
**Сэдвийн агуулга:** Уг судалгааны бичвэрт хотыг дахин хөгжүүлэхэд хууль эрхзүйн орчныг хэрхэн бүрдүүлэх, иргэн бусад хуулийн этгээдээс түүний эдэлбэр газрыг улсын хэрэгцээнд авах шаардлага, үндэслэл юу болох, газрыг албадан авах үеийн зохицуулалт, газар болон үл хөдлөх хөрөнгийг үнэлэх аргачлал, үнэ төлбөр төлөх зохицуулалт зэрэг талаар Казахстан улсын эрхзүйн орчны хүрээнд судалсан лавлагаа мэдээллийг тусгасан болно.  
**Хайлтын түлхүүр үг:** хотыг дахин хөгжүүлэх, газрыг улсын хэрэгцээнд авах үндэслэл, шаардлага, газрыг улсын хэрэгцээнд албадан авах, газрын нөхөн төлбөр, эдэлбэр газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ

### **МОНГОЛ УЛС ДАХЬ УРАНЫ ХАЙГУУЛ, ОЛБОРЛОЛТ, АШИГЛАЛТ, ЦАЦРАГ ИДЭВХТ ХОГ ХАЯГДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

**Судалгааны код:** СТ-14/501  
**Судалгааны төрөл:** Дүн шинжилгээ  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Болормаа, Ц.Элбэгзаяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Ж.Батзандан  
**Огноо:** 2014.02.07  
**Сэдвийн агуулга:** Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн сангаас олон улсын гэрээ конвенц, хууль, бодлогын баримт бичиг, Үндэсний болон засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөө, салбарын дүрэм журам гэх мэт нийт 41 эрх зүйн баримт бичиг байх бөгөөд үүнээс хууль болон бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдийн хүрээнд судалгааны анализ хийлээ.